

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга 0

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-5

---

1. Байнгын хорооны даргыг сонгох тухай 3-5

2. Дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай 5-6

**Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн бүрэн эрхийн анхдугаар чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны  
2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 58 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, М.Бадамсүрэн, Р.Батболд, Ж.Батсуурь, Х.Баттулга, Ж.Бат-Эрдэнэ, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу.

**Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл нар Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлсэн талаар танилцуулав.

Нэр дэвшигчээс болон танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл, Д.Энхтүвшин, Ж.Ганбаатар нар үг хэлэв.

**Ж.Ганбаатар:** Эдийн засгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15  
Татгалзсан: 2  
Бүгд: 17  
88.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр.Дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах талаар Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс ирүүлсэн саналыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн саналыг Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж нар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа, Б.Мөнхсоёл нар Дэд хорооны бүрэлдэхүүнд орох санал гаргав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн тавьсан асуултад хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар хариулж, тайлбар хийв.

**Ж.Ганбаатар:** Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороог Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, М.Бадамсүрэн, Э.Батшугар, М.Мандхай, Л.Соронзонболд, М.Энхцэцэг, А.Ундраа, Б.Мөнхсоёл, П.Батчимэг, Б.Жаргалан нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15  
Татгалзсан: 2  
Бүгд: 17  
88.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 17 минут үргэлжилж, 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 15 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Ж.ГАНБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим, 14 цаг 58 минут

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Ж.Ганбаатар:** Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг дахин эрье. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн байна. Хувь нь хэд юм. 68 хувьтай бүрдсэн байна. Тэгээд хэлэлцэх асуудалдаа оръё. 2 асуудал хэлэлцэнэ.

1 дүгээрт Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудал хэлэлцэнэ.

2 дугаарт Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны бүрэлдэхүүний тухай хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудлаа баталлаа.

Эхний асуудалдаа оръё.

**Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцье.**

Улсын Их Хурал дахь олонхын бүлгээс Эдийн засгийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх асуудлыг танилцуулна. Мөнхбаатар даргын микрофоныг өгье.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн амрыг эрье. 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан Улсын Их Хурал дотоод бүтцийнхээ байгууллагуудыг байгуулж байна. Ингэхдээ Улсын Их Хуралд авсан суудлын тоо, ард иргэдийн өгсөн саналыг харгалзан үзэж Улсын Их Хуралд суудалтай намуудтай хамтран ажиллах зөвшилцлийн хүрээнд Монгол Ардын намын зүгээс Ардчилсан нам, ХҮН

намтай хамтран ажиллаж, зөвшилцсөний дүнд Эдийн засгийн байнгын хороог Ардчилсан намын зүгээс ахлан ажиллах нь зүйтэй гэж үзсэн.

Тийм учраас та бүхэн Ардчилсан намаас нэр дэвшүүлсэн Улсын Их Хурлын гишүүнийг Байнгын хорооны даргад дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье.

**Ж.Ганбаатар:** Тэгээд хэн танилцуулах юм. Цогтгэрэл гишүүний микрофоныг өгье.

**О.Цогтгэрэл:** Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан даргалагч болон гишүүдийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үр дүнгээр намуудын суудлын харьцаа дээр бас зөвшилцөл, ойлголцлын асуудлууд явагдаж Байнгын хороог тодорхой түвшинд удирдахаар энэ асуудал яригдсан. Энэ хүрээнд Ардчилсан нам, Ардчилсан намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Ренчинбямбаагийн Сэддоржийг Эдийн засгийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байна.

Сэддорж гишүүний товч танилцуулгыг та бүхэнд хүргэе.

1988-1997 онд Өмнөговь аймгийн Даланзадгад хотын 1 дүгээр 10 жилийн сургуулийг, 1997-2002 онд Хан-Уул дээд сургуулийг Бизнесийн эдийн засагч мэргэжлээр Улаанбаатар хотод Хан-Уул дээд сургуулийг бас Хэрэглээний математикч мэргэжлээр хос мэргэжлээр төгсжээ. Мөн 2010-2012 онд Америкийн Нэгдсэн Улсын Канзасын Их сургуульд тухайн чиглэлээр Эдийн засгийн ухааны магистр хамгаалсан байна.

Ажилласан байдлын хувьд:

2004-2007 онд Улсын Их Хурлын гишүүний бие төлөөлөгчөөр, 2013 онд Өмнөговь аймгийн Засаг даргын Байгаль орчин, уул уурхайн асуудал хариуцсан орлогч даргаар, мөн Улсын Их Хурлын

гишүүнээр сонгогдох хүртлээ 2020 оноос эхэлж Өмнөговь аймгийн Засаг даргаар ажиллаж ирсэн ийм туршлагатай, эдийн засгийн мэргэжилтэй нэр дэвшигч байна.

Та бүхнийг Ренчинбямбаагийн Сэддоржийг Эдийн засгийн байнгын хорооны даргад хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье.

**Ж.Ганбаатар:** Цогтгэрэл даргад баярлалаа. Нэр дэвшүүлж байгаа Сэддорж гишүүнээс асуух асуулттай Байнгын хорооны гишүүд байна уу. Асуулттай гишүүн байна уу. Байхгүй юу. Үг хэлэх гишүүн байна уу. Кнопоо дараарай. Би үг хэлнэ. Энхтүвшин гишүүнээр тасаллаа. Батсүмбэрэл гишүүн үг хэлье. Асуулт биш үг шүү.

**Н.Батсүмбэрэл:** Сэддорж гишүүнд амжилт хүсье. Тэгээд энэ сонгуулийн дүнг харж байгаад Монгол Ардын намаас хэдийн олонх болсон боловч улс орны өмнө хүлээгдэж байгаа төслүүдийг явуулах үүднээс Засгийн газарт бусад намуудын төлөөллийг оролцуулж, цаашлаад Их Хурлын бүтцэд оруулж байгаа юм байна гэж ойлголоо. Сая 2 бүлгийн даргын мэдээллээс. Тэгээд Сэддоржид мэднэ. Тэгээд Сэддорждоо хэлэхэд бол Эдийн засгийн байнгын хороо дээр ажлаа явуулахдаа улс төрийн байр сууринаас асуудалд хандалгүй улс орныхоо эрх ашгийг тэргүүнд тавьж, ул төрийн намуудын мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн тэр эдийн засгийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг явуулах, урагшлуулах асуудал дээр анхаарч ажиллаарай гэдгийг зориуд захиж хэлье.

Өмнөговь аймагтай адил бусад аймгуудыг хөгжих бололцоогоор нь хангаж өгөх, томоохон уул уурхайн төслүүдийг урагш нь хөдөлгөх, төмөр замын болон бусад боомтуудыг бодит ажил болгох, Улаанбаатар хотын өмнө тулгамдаад байгаа эдийн засгийн боломжуудыг нээх тал дээр их анхаарч ажиллаарай. Улаанбаатар хот бол хүн амын тал нь амьдардаг хэр нь эрх зүйн

хувьд их боогдмол, эдийн засгийн хувьд хязгаарлагдмал байдалтай байдаг. Энийг Эдийн засгийн байнгын хороо онцгой анхаарч, Эдийн засгийн байнгын хорооноос холбогдох асуудлуудыг шуурхай шийдэж, Улаанбаатар хотын өмнө тулгамдаад байгаа асуудлыг шийдэх тал дээр анхаарч ажиллаарай гэдгийг зориуд шинэ сонгогдож байгаа Байнгын хорооны даргад хэлж, захиж байна.

**Ж.Ганбаатар:** Захиас хэллээ. Баярлалаа. Энэ минут нь хаан явдаг юм бэ. Гишүүд минутаа хараад үгээ төлөвлөх ёстой шүү дээ. Хэзээ дуусгах вэ гээд. Энхтүвшин гишүүн үг хэлье.

**Д.Энхтүвшин:** Энэ удаагийн Улсын Их Хурлын сонгууль бас нэлээн хариуцлагатай Улсын Их Хурлын хугацаа байгаа. Өөрөөр хэлбэл өмнө нь бас мөрийн хөтөлбөрүүд дээр дурдагдсан олон ажлууд яг бодит амьдрал дээр хэрэгждэггүй байсан. Тэгэхээр энэ жилийн сонгуулийн хувьд бол яг ард иргэдийн хувьд, аж ахуйн нэгжүүдийн хувьд эдийн засгийн орлого, ахуй амьжиргаа нь шууд сайжирсан ийм үр дүн, дараагийн 4 жил ийм байгаасай гэж хүсэж байна. Энэтэй холбоотой хувийн хэвшлийн үүрэг оролцоо бол маш чухал байгаа. Эдийн засгийн өсөлтийг жигд хүртээмжтэй болгох хамгийн дөт зам бол хувийн хэвшлийг дэмжих байгаа. Тэгээд энэ чиглэлээр Эдийн засгийн байнгын хороо бол нэлээн их ажлууд хийнэ гэж бодож байгаа. Энэтэй холбоотой хувийн хэвшлийг дэмжихтэй холбоотойгоор хувийн өмчийн эрхтэй холбоотой асуудлууд дээр нэлээн анхаарч ажиллах хэрэгтэй санагдаж байгаа. Сүүлийн жилүүдэд бас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотойгоор таслан сэргийлэх арга хэмжээнүүдийг хэтрүүлж хэрэглэж байгаа үйл явдлууд нэлээн харагдаж байгаа. Ялангуяа аж ахуйн нэгжүүдийн дансыг хаадаг, татварын хууль тогтоомжууд нь жишээлбэл бодит амьдралаас нэлээн хол байдаг учраас тэрнээс болоод татвар

жишээлбэл нийгмийн даатгал данснуудыг хаадаг ийм ажиллагаанууд байдаг. Энэ өмчийн эрхэд халдаж байгаа энэ зохицуулалтуудыг илүү тодорхой болгох чиглэлээр бас ахиц дэвшил гаргана байх гэж бодож байна.

Тэрнээс гадна аж ахуй нэгжүүдийн хувьд бас дэд бүтэцтэй холбоотой асар их нэмэлт хөрөнгө оруулалтуудыг гаргадаг. Тэгээд энэ дэд бүтцийн салбаруудын нийт аж ахуйн нэгжийн дэд бүтэцтэй холбоотой төслүүдийг нэлээн хурдтай, 4 жил богино хугацаа учраас илүү эрчтэй ажиллахыг, дээр нь мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжуудыг бас яг хэрэгжүүлэх тал дээр нэлээн анхаарч ажиллах ийм зайлшгүй шаардлагатай харагдаж байгаа.

Тэгээд Сэддорж гишүүний хувьд өмнө нь хувийн хэвшилд ажиллаж байсан хүний хувьд бас энэ чиглэлээр нэлээн ойлголттой, Эдийн засгийн байнгын хорооны гишүүдээ дайчилж, мөн Их Хуралтай болон бусад чиглэлийн яамнуудтай нэлээн ойрхон хамтарч ажиллана байх гэж бодож байна. Тэгээд амжилт хүсье.

**Ж.Ганбаатар:** Баярлалаа. Би 2 зүйл хэлье. Эдийн засгийн байнгын хороо нийт өнгөрсөн жилүүдийг харж байхад бол нийт хэлэлцэж байгаа асуудлыг бараг 60 хувь Эдийн засгийн байнгын хороогоор ордог. Сэддорж дарга аа, тэгээд өөр Байнгын хороонууд чинь эдийн засагтай холбоотой асуудлуудыг урдуур чинь ороод авах гээд байдаг ч юм уу, ер нь хууль зөрчсөн асуудлууд Байнгын хороогоор даваад Их Хурал руу орох тийм зүйлүүд байдаг шүү. Тэрийгээ сайн шалгуураа сайн хангаарай. Хуралд орж байгаа асуудлуудыг өрөөндөө 2 өдөр бэлдэх хэрэгтэй болдог. Тэрийгээ сайн анхаарна биз. Тэгээд энд тэндээс хууль зөрчсөн асуудал оруулж ирвэл Байнгын хорооны дарга хэлэлцүүлэхгүй байх бүрэн эрхтэй. Хууль зөрчсөн нэг үг л байвал

тэрийг хэлэлцүүлэхгүй байх бүрэн эрх байгаа шүү танд.

Тэгээд Байнгын хорооныхоо гишүүдээс дэмжлэгээ сайн аваад, зөвлөгөө аваад хэрвээ хүсвэл тэгээд явах бүрэн боломж байгаа. Эдийн засгийн холбоотой асуудалгүй асуудал гэж Монголд байхгүй. Тэгээд юу гэдэг юм Үйлдвэржилтийн байнгын хороо гэдэг юм уу, Төсвийн байнгын хороо гэдэг юм уу тэгээд хөндлөнгөөс асуудалд хамааралгүй Байнгын хороо янз янзын юм ярих гээд байдаг. Тэгээд дахиад хэлэхэд хууль зөрчсөн, хуулийг давсан юм Засгийн газраас ч гэсэн барьдаг, гишүүдээс ч гэсэн орж ирдэг. Хууль сайн баримтлаарай. Тэгээд хөндлөнгийн нөлөөнд бага автаарай гэдгийг хэлье. Ер нь тэгээд Тамгын газраас ч гэсэн зарим зүйлийг нүд аниад буруу зөрүү зүйл явдаг шүү. Тэрийг бас хувь гишүүнийхээ хувьд хуулийг сайн баримтлаад, сайн ажиллах байх гэдэгт итгэж байна. Тэгээд амжилт хүсье. Бүгдээрээ нэг алга ташаад баяр хүргэчих үү.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ренчинбямбаагийн Сэддоржийг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт гишүүд ээ. 88.2 хувиар санал дэмжигдлээ. Байнгын хорооны гишүүддээ баярлалаа. Дараагийн асуудлыг дарга удирдах юм уу. Байнгын хорооны санал дүгнэлтийг чуулган дээр унших гишүүн байна уу. Сайн дураараа. Энхтүвшин гишүүн. Мааш хурдтай байна шүү.

15.11 цаг.

Дараагийн асуудалд оръё. Гишүүд түр байж байгаарай. 2 минут.

**Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.**

Дэд хорооны бүрэлдэхүүнийг Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн төлөөллийг харгалзан ... цөөнхийн төлөөллийн нэр ирсэн юм уу. Сэддорж дарга аа, цөөнхийн төлөөллийн нэр ирээгүй байна. Та нэрээ бодож байгаарай. Дэд хороонд орох Улсын Их Хурлын гишүүдийн нэрийг Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгээс ирүүлсэн байгаа. Эдгээр нэрсийг уншиж танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал, Бадамсүрэн, Батишугар, Мандхай, Соронзонболд, Энхцэцэг гэсэн хүмүүс байна. Одоо 4 хүн нэр дэвшүүлэх бололцоотой байна. Та өөрөө нэрээ хэлчих. Хэн хэн байх юм.

**Р.Сэддорж:** Ярилцаж амжаагүй байна л даа.

**Ж.Ганбаатар:** Тэгвэл хойшлуулах уу. Чуулган руу орох юм байна. Алив Сэддорж дарга яах уу. Ундраа гишүүн орох уу. Сэддорж дарга аа, Ундраа гишүүн орох юм байна. Мөнхсоёл гишүүн. Мөнхсоёл гишүүн, Ундраа гишүүн, Батчимэг гишүүн яах юм. Батчимэг гишүүн орохоос өөр арга байхгүй юм байна. Батчимэг гишүүн. Сэддорж даргын микрофоныг өгье. Сэддорж дарга аа, Мөнхсоёл гишүүн, Ундраа гишүүн 2-ыг заавал хэлээрэй.

**Р.Сэддорж:** Манай цөөнхийн бүлгээс Ундраа гишүүн, Мөнхсоёл гишүүн, Батчимэг гишүүн, Жаргалан гишүүн гэсэн 4 хүн.

**Ж.Ганбаатар:** Дэд хорооны бүрэлдэхүүнд нэр дэвшсэнтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Энхтүвшин гишүүний микрофон өгье.

**Д.Энхтүвшин:** Ардын намаас сая санал уншсан. Тэр нь ямар бүтцээр сая уншсан бэ. Зарим хүмүүсийн хувьд ойлголт тодорхойгүй учраас жишигээр давхардаад нэр дэвшүүлэх асуудал гарч байна. Албан бичгээр ирсэн юм уу.

**Ж.Ганбаатар:** Мөнхбаатар даргаас ирсэн байна.

**Д.Энхтүвшин:** Өмнө нь бас яг энэ асуудлаар ярилцаад, өөр юм ярьж байснаа орж ирэхдээ шал өөр болчихсон байна.

**Ж.Ганбаатар:** Мөнхбаатар даргатай яриарай. Тэгэхээр бид бол яахгүй байна гэсэн үг. Асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Санал хураалт явуулъя.

Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороог Улсын Их Хурлын 11 гишүүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд ээ, анхааралтай байхыг хүсье. 88.2 хувиар санал дэмжигдлээ.

Эдийн засгийн байнгын хороонд ажиллах гэж байгаа 4 жил нь эхэлж байгаа шижигнэсэн сайхан эрч хүчтэй гишүүд дээ амжилт хүсье. Сайн сайхныг хүсье. Баярлалаа.

Санал, дүгнэлт унших гишүүн байна уу. Батсүмбэрэл гишүүн уншъя. Баярлалаа.

Байнгын хорооны хуралдаан өндөрлөлөө.

15.15 цаг

**Дууны бичлэгээс буулгасан:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ